

МОНГОЛ-ОРОС, МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

/Хөрш орнуудтай 2003 онд харилцсан тухай/

*О.Энхтөр**

Монгол Улсын гадаад орчинд 1980/90-ээд оны заагаас эхлэн таатай нөхцөл бүрэлдсэнээр үндэсний ашиг сонирхолд нийцсэн, бие даасан гадаад бодлого хэрэгжүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг бэхжүүлэх өргөн бололцоог нээсэн билээ. Манай төр, засаг гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ энэ нөхцөл бололцоог бүрэн дүүрэн ашиглахыг зорьж ирэв.

Монголыг хүрээлэн байгаа хөрш зэргэлдээ орнууд хөгжлийн ерөнхий чиг хандлагын хувьд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг бус, соёл иргэншлийн нийтлэг үнэт зүйлийг эрхэмлэх болж, ардчилал, зах зээлийн харилцааг баримжаа болгож байгаа нь тэдэнтэй найрсаг хөршийн харилцааг хөгжүүлэх боломжийг олгож байна. ОХУ, БНХАУ-тай харилцах асуудлыг тэргүүлэх ач холбогдолтой хэмээн Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон, эдгээр оронтой байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ, удаа дараа гаргасан хамтарсан мэдэгдлүүдийн үзэл санааны дагуу ОХУ, БНХАУ-тай харилцах харилцааг улам бататган гүнзгийрүүлж, үр өгөөжийг нь дээшлүүлэхэд онцгой анхаарч ажилласны үр дүнд, 2003 онд хөрш хоёр оронтой харилцаа, хамтын ажиллагаанд чанарын шинэ дэвшил гарсан гэж үзэж байна.

Монгол-Оросын харилцаа

Монгол Улс, ОХУ-ын уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг бүх салбарт сэргээн хөгжүүлэх, ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх чиглэлээр хоёр талаасаа хүчин чармайлт гарган ажилласны үр дүнд дээд, өндөр хэмжээнд зарчмын ач холбогдолтой айлчлалууд хэрэгжиж, төр, засаг, төв, орон нутаг, аж ахуйн байгууллагуудын хоорондын ажил хэрэгч хэлхээ холбоо, яриа, хэлэлцээ бүхэлдээ идэвхжив.

Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Монгол Улсын Ерөнхий аудитор, Үндсэн хуулийн Цэлийн дарга нар ОХУ-д тус тус албан ёсны, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нар ажлын айлчлал хийж, ОХУ-

*О.Энхтөр - Гадаад Хэргийн Яамны Хөрш орнуудын газрын захирал

ын Засгийн газрын орлогч дарга, Хөдөө аж ахуйн сайд А.Гордеев, Соёлын сайд М.Е.Швыдкой нар Монгол Улсад айлчлав.

Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлал Монгол-Оросын харилцааны 2003 оны гол үйл явдал байв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай хамтарсан албан мэдээ, бусад баримт бичгүүд байгуулж, харилцаанд хуримтлагдсан асуудлуудыг хэлэлцэж, багцаар шийдвэрлэхэд бодитой ахиц гаргасан юм. Айлчлалын дүнгээр гаргасан Хамтарсан албан мэдээнд “Сайн хөршийн уламжлалт түншлэлд баттай тулгуурласан Монгол, Оросын харилцааны онцгой шинж чанар түүхэн шинэ нөхцөлд халгалагдан хөгжиж байгааг” цохон тэмдэглэж, “сайн хөршийн уламжлалт түншлэл” гэсэн томъёоллыг Монгол-Оросын харилцаанд анх удаа хэрэглэж, дээд хэмжээний баримт бичигт тусгасан нь шинэлэг зүйл байв. Энэхүү айлчлалаар шилжих рублийн зээлийн өрийн асуудлаар улс төрийн нэгдмэл байр сууринд хүрч, “стандартын бус”, онцгой хөнгөлөлттэй нөхцлөөр тохиролцсон нь оны эцэс гэхэд үр дүнгээ өгч, “их өр” гэж нэршсэн өрийн дарамт үгүй болсон нь хоёр орны харилцааны түүхэнд төдийгүй Монголын үндэсний түүхэнд шинэ хуудас нээсэн үйл явдал боллоо. Эл түвэгтэй асуудлаар аль аль тал нь хүлээж авахуйц улс төр-санхүүгийн шийдэлд хүрсэн нь олон жилийн турш манай төр, засгаас тавьж ирсэн хүчин чармайлтын үр дүн бөгөөд Монгол, Оросын харилцааны саарлын үеийг даван туулж, уламжлалт түншлэлээ шинэ нөхцөл байдалд сэргээсний нэг илэрхийлэл боллоо.

Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн харилцаанд шийдлээ хүлээж байсан асуудлууд 2003 онд амжилттай шийдвэрлэгдэж, тодорхой ахиц гарсан нь “Эрдэнэт” үйлдвэр, “Монголросцветмет” нэгдлийг барьж байгуулахад зориулж, Монгол Улсын авсан зээлийн тооцоог хийж, барагдсанд тооцсон, ОХУ-ын өмчийн орон сууцны тодорхой тооны байшинг Монголын талд шилжүүлэн өгөх болсон, баруун бүсийн эрчим хүчний үнийг бууруулахаар тохиролцсон, Оросын талын тэтгэлгээр суралцах оюутны тоог нэмэх, түүний дотор соёл, урлагийн мэргэжлээр суралцуулах боломжийг өргөтгөсөн, шилжих рублийн зээлийн өрийн асуудлаар улс төрийн нэгдмэл байр сууринд хүрч, “стандартын бус”, онцгой хөнгөлөлттэй нөхцлөөр шийдсэн зэргээс тодорхой харагдаж байна.

Хоёр орны гадаад худалдааны нийт эргэлт бага зэрэг өссөн боловч, манай талд ихээхэн алдагдалтай байдал хэвээр үргэлжилсээр байна. Үүнд манай экспортын ерөнхий чадавхи сул, ОХУ-аас түлш, эрчим хүчний болон технологийн хамаарал хүчтэй хэвээр байгаа нь гол хүчин

зүйл болж, энэ байдал цаашдаа нэлээд хугацаагаар үргэлжлэх нь тодорхой боловч ОХУ-ын гаалийн, тээврийн зэрэг татвар, тариф өндөр байгаа, тарифын бус бусад хязгаарлалтууд үйлчилж байгаа нь Монголын экспортын бараа Оросын зах зээлд өрсөлдөх боломжийг явцууруулж байгаатай мөн холбоотой юм. Иймд Монгол, Оросын хоорондын худалдааг либералчлах асуудлыг бид чухалчлан тавьж байна. /Энэ тухайд саяхан манай оронд ОХУ-ын Гадаад хэргийн сайд айлчлах үеэр мөн онцлон ярьсан болно/ Үүнд ЗГХК, ОХУ ДХБ-д элсэхтэй холбогдуулан хийж буй олон талт хэлэлцээ, худалдааг либералчлах хоёр талын хэлэлцээ зэрэг механизмууд, түүнчилэн улс төрийн яриа хэлэлцээг идэвхтэй ашиглах болно.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын харилцааг 2002-2004 онд идэвхжүүлэх талаар Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөг тохиролцсоноор хамтын ажиллагааны тулгамдсан асуудлууд, юуны өмнө манай улсын ашиг сонирхлын хүрээний асуудлуудаар ОХУ-ын яам, байгууллагуудтай илүү тодорхой ажиллах нөхцлийг бүрдүүлэв. Ийнхүү хамтын ажиллагааны удаан жилээр сунжран яригдаж буй асуудлуудыг шийдэх цаг хугацааны хязгаарлал тогтоож өгсөн нь манайд ач холбогдолтой болов.

Монгол, Оросын хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа урьдын адил анхаарлын төвд байна. Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны салбар комиссын III хуралдаан Новосибирскт хотод 2003 оны эхээр хуралдаж, Ерөнхий сайдыг айлчлалынх нь хүрээнд Чита, Эрхүү, Кемерово мужид зочлуулж, ОХУ-ын эдгээр субъекттэй хамтран ажиллах өргөн хүрээтэй асуудлаар санал солилцов. УИХ-ын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээнд оролцож, БНБуриадУ-ын Ерөнхийлөгч бөгөөд Засгийн газрын дарга Л.В.Потапов Улаанбаатар, Хэнтийд тус тус айлчлав. Хэнтий аймаг болон Буриадын Заиграево муж хоорондын хамтын ажиллагааны тухай Протокол, Баянхонгор аймаг, Буриадын Кабанын районы хоорондын харилцаа, хамтын ажиллагааны тухай Протокол, Говь-Сүмбэр, Сэлэнгэ аймгууд болон Буриадын Кабанын районы хоорондын хамтын ажиллагааны тухай Протокол тус тус байгуулж, гарын үсэг зурав.

Байгаль-Хөвсгөлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн эхний үе шатыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд Эрхүү муж, БНБуриадУ-ын удирдагчидтай Хөвсгөлд уулзсан нь бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлж урагшлуулахад тодорхой түлхэц өгсөн

юм. Тухайлбал Монгол-Оросын хилийн Ханх-Монд шалган нэвтрүүлэх боомтыг олон улсын статустай болгох, гурав дахь орны жуулчдыг хүлээж авах, Хөвсгөл-Байгаль чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Хөвсгөл нуурын орчим байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалах, байгаль орчин, экожуулчлалын эхлэл ийнхүү тавигдлаа.

Батлан хамгаалах салбарт уламжлалт цэрэг-техникийн хамтын ажиллагаанаас гадна терроризмтай тэмцэх тусгай анги салбар манайд байгуулах, тэнд ажиллах мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэхэд ОХУ-аас тусламж үзүүлэхийг дээд хэмжээнд хүсэлт болгосны дагуу засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна. Монгол-Оросын найрамдлын сарын ажлыг Монголд сэргээн зохион байгуулж, энэ хүрээнд Новосибирск мужийн соёлын өдрүүд, Мосфильмын кино 7 хоног, Усть-Ордын автономит тойргийн соёлын өдрүүд Улаанбаатарт, Монголын соёлын өдрүүдийг ОХУ-д тус тус зохиогдов. ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцагсдын тоог 200 хүргэх, түүний хүрээнд соёл, урлагийн чиглэлээр суралцагсдын тоог нэмэхээр тохирсон нь дурдсан салбарын хамтын ажиллагааны ахиц байлаа.

Дүгнэж үзэхэд, 2003 онд Монгол Улс, ОХУ-ын уламжлалт түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа улам бэхжиж, өмнөх үеэс уламжлагдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зарчмын нааштай ахиц гарч, хамтын ажиллагааны шинэ таатай нөхцлийг бүрдүүлснээрээ онцлогтой байлаа гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Монгол-Хятадын харилцаа

2003 он Монгол-Хятадын харилцааны хувьд онцлог жил байлаа. Хятад болон Азийн зарим оронд SARS өвчин гарсны улмаас төлөвлөсөн зарим ажил хойшлогдсон ч харилцаа бүхэлдээ амжилттай өрнөв. Оны эхний улиралд БХАТИХ-ын ээлжит чуулган чуулж, Хятадын төр, засгийн дээд удирдлага солигдсон нөхцөл байдалд харилцааны залгамж чанарыг хангах зорилтыг хоёр талаас тавьж, амжилттай хэрэгжүүлэв. БНХАУ-ын шинэ дарга Монгол Улсад төрийн айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны гол үйл явдал болов. Ийнхүү БНХАУ-ын дарга Ху Жинтао төрийн тэргүүний хувиар гадаад орнуудад хийсэн анхны айлчлалынхаа хүрээнд манай оронд айлчилсан нь тус улсын шинэ удирдлага Монгол-Хятадын харилцааг чухалчлан үзэж байгаагийн илэрхийлэл болсон бөгөөд хоёр талын харилцаанд ач холбогдолтой байсан төдийгүй манай улсын нэр хүндийг гадаад ертөнцөд өргөхөд хувь нэмэр болов. Айлчлалын дүнгээр хоёр тал Хамтарсан мэдэгдэл гаргаж, Монгол,

Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлэхээ санал нэгтэй мэдэгдсэн нь хоёр орны харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг үнэлэн дүгнэж, шат ахисныг илэрхийлсэн хэрэг боллоо.

Хоёр орны парламент хоорондын харилцаа идэвхтэй явагдав. Азийн парламентуудын олон улсын хурал, чуулганы үеэр парламентын тэргүүн нарын түвшинд уулзалтууд болж, УИХ-ын ГБББХ-ны дарга Хятадад айлчилсныг энд дурдаж болно. Хоёр ГХЯ-дын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Хятадын ГЯЯ-ны дэд сайд Монгол Улсад айлчилж, ГХЯ-дын зөвлөлдөх уулзалт хийв. БНХАУ-ын Улсыг аюулаас хамгаалахын сайд Монголд, манай Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайд, үйлдвэр худалдааны сайд нар Хятадад тус тус айлчилсан нь тухайн салбарын харилцааг хөгжүүлэхэд ач холбогдолтой болов.

Хоёр улсын хилийг хоёрдахь удаа хамтран шалгах ажил амжилттай явагдаж байна. Хоёр орны харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх чиглэлээр анхааран ажиллаж байна. “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрт өөрчлөлт оруулах хоёр удаагийн хэлэлцээ Улаанбаатар, Бээжинд болж, шинэ хэлэлцээрийг үндсэнд нь тохиролцов. Улс төрийн нам хоорондын харилцааны хүрээнд МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ардчилсан намын дарга тэргүүтэй намын төлөөлөгчид тус тус Хятадад айлчлав.

БНХАУ манай гадаад худалдааны хамгийн том түнш хэвээр байж, гадаадын хөрөнгө оруулалтыг тэргүүлсээр байна. Худалдаа-эдийн засгийн салбарт хөгжлийн томоохон төсөлд түлхүү анхаарах, худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн түвшинг тогтвортой байлгах зорилт тавьж, Монгол Улсад үзүүлэх хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хэмжээг бууруулахгүй байх, тэдгээрийг оновчтой ашиглахад голлон анхаарав. Хятадын талаас 80 сая юаний буцалтгүй тусламж үзүүлж, 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох саналыг тавив. БХЯ-нд 8 сая, Хил хамгаалах ерөнхий газарт 1 сая юаний буцалтгүй тусламж олгосон нь хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд зохих дэмжлэг боллоо. Манай зүгээс ч Хятадад тусламжаа үзүүлж байлаа. Шинжаанд хүчтэй газар хөдөлж ихээхэн хэмжээний гарз хохирол учирсантай холбогдуулан манай тал сайн санааны илэрхийлэл болгож 10 сая төгрөгний үнэ бүхий барааг Хятадын Улаан загалмай нийгэмлэгт гардуулав.

Соёл, боловсролын салбарт хамтын ажиллагаа өргөжсөөр байна. БНХАУ-д суралцуулах оюутны тоог нэмэх талаар хоёр тал ярилцаж байгаа, 2004 онд Хятадын Соёлын өдрүүдийг Монголд зохион.

байгуулахаар бэлтгэж буйг дурдаж болох юм. Монгол-Хятадын хооронд “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээр байгуулсан бөгөөд Хятадын засгийн газар Монгол Улсыг “БНХАУ-ын иргэд өөрийн зардлаар жуулчлах улсуудын жагсаалтад” оруулж байгааг мэдэгдсэн нь аялал жуулчлалын хамтын ажиллагаа хөгжих нөхцлийг бүрдүүлэв. МИАТ-ийн удирдлага гадаад нислэгийн тоог цөөлөх шийдвэр гаргасны улмаас олон жил ярьж, ихээхэн ажил болж байж шийдвэрлүүлсэн зарим асуудлыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсныг анхаарах шаардлагатай байна.

Бүхэлд нь дүгнэж үзэхэд, Монгол Улс, БНХАУ-ын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлэх улс төрийн таатай уур амьсгал бүрдэж, цаашдын хөгжлийн шинэ хандлагын үндэс суурь тавигдлаа.

Тайвань, Далай ламын холбогдолтой асуудлыг харилцан ойлголцлын хүрээнд авч явж байгаа нь чухал юм. Тодруулж хэлбэл, Тайваньтай харилцахдаа “нэг Хятадын” бодлогыг баримталж, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн харилцааг прагматикаар хөгжүүлэх нь зүйтэй бөгөөд үүнд БНХАУ-ыг Тайваниар “солих” нь манай эрх ашигт огт нийцэхгүйг, Далай ламын тухайд ард иргэдийнхээ шүтэн бишрэх эрхийг хүндэтгэх явдал эн түрүүний зарчим хэмээн тууштай хамгаалах шаардлагатайг иш үндэс болгож байна. Цаашдаа ч энэ маягаар үргэлжлүүлэх бүрэн найдлагатайг саяхан манай Гадаад харилцааны сайд БНХАУ-д айлчлах үеийн яриа, хэлэлцээ харуулав. Айлчлалын хүрээнд манай Засгийн газрын гишүүн сүүлийн жилүүдэд анх удаа Түвдэд зочилсныг хоёр тал нааштай үнэлж байгааг дашрамд тэмдэглэе.

Дүгнэлт

ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцааг манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилт хэрэгжиж байна. Хөрш хоёр оронтой түншлэлийн харилцаа хөгжүүлэхээр дээд, өндөр хэмжээнд тунхагласан явдал шинэлэг зүйл юм. Харилцааны түвшинг ийнхүү томъёолсон нь хөрш орнуудтай харилцаагаа түүхэн шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн арав гаруй жилийн хүчин чармайлт, Монгол Улсын Засгийн газраас сүүлийн гурван жил гаруй хугацаанд гүйцэтгэсэн тодорхой ажлын үр дүнг нэгтгэн дүгнэсэн хэрэг бөгөөд энэ алхмыг цаг хугацааны хувьд уялдаатай хийсэн нь хөрш хоёр гүрэнтэй тэнцвэртэй харилцах чиг шугамд нийцэж байна.

Хөрш орнуудтай сайн хөршийн түншлэлийн харилцааг цаашид бататган хөгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Орос, Хятадын эдийн засгийн ашиг сонирхлыг Монголд байлгах
- Сибирь, Алс Дорнодыг бүс нутгийн хамтын ажиллагаанд түлхүү оролцуулах ОХУ-ын бодлого, баруун болон хойд нутгаа хөгжүүлэх БНХАУ-ын стратегийн төлөвлөгөөтэй Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг уялдуулан хэрэгжүүлэхэд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг чиглүүлэх,

- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулж, либералчлах, хоёр хөрш орны зах зээлд идэвхтэй ажиллах

- Соёл, шинжлэх ухаан, боловсролын хамтын ажиллагааг хөгжүүлэх

- Тээвэр харилцааны боломжийг улам бүр өргөтгөх,

- Иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх,

- Хөрш орнуудын бүс нутаг, хил орчмын мужуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал чухал бөгөөд энэ хүрээнд, монгол угсаатнууд оршин суудаг нутаг, оронтой худалдаа, эдийн засаг, соёлын чиглэлээр боломжийн хэрээр түлхүү харилцах бодлогыг хамтад нь авч явах, эдгээр болно.

Хөрш орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд манай ТББ, бизнесийн хүрээнийхэн, олон нийт идэвхтэй хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэхэд таатай байна. Тухайлбал, 2003 оны жишээгээр ярихад, Монгол, Оросын найрамдлын сарын арга хэмжээг арав гаруй жилийн дараа сэргээн зохион байгуулсан, БНХАУ-аас манай улсад ажиллаж байсан үе үеийн элчин сайд нарыг найрамдлын нийгэмлэгийн шугамаар урьж айлчлуулсан зэрэг нь харилцааны нийт уур амьсгалыг улам дотно болгоход ихээхэн нөлөөлсөн алхам болсныг цохон дурдах нь зүйтэй. Энэ бол хөрш хоёр гүрэнтэй найрсгаар харилцаж, хамтран ажиллах төр, засгийн бодлого Монголын олон нийтийн дэмжлэгийг хүлээж байгаагийн тодорхой илэрхийлэл гэж үзэж байна.

Түүнчилэн, хөрш орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг найрсгаг түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх бодлого зөвхөн ганц /Монголын/ талын хүчин чармайлтын үр дүн бус, ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого, түүний дотор Монгол Улстай харилцах бодлоготой уялдан дүйсний үрээр амжилттай хэрэгжиж байгаа нь ойлгомжтой билээ. Энэ нэгдүгээр сарын дундуур Монгол Улсын Гадаад хэргийн сайд БНХАУ-д, ОХУ-ын Гадаад хэргийн сайд Монголд тус албан ёсоор айлчлах үеэр болсон яриа, хэлэлцээний явц манай улсуудын хооронд харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх эрмэлзэл аль аль талд байгааг дахин нотлон харуулав. Тухайлбал, ОХУ-ын Гадаад хэргийн сайд И.С.Иванов МУИС-д үг хэлэхдээ

ОХУ-ын Азийн чиглэлийн бодлого, улсынхаа эргэн тойронд сайн хөршийн харилцаа, тогтвортой байдлын бүсийг бүрдүүлэх зорилтын талаар зарчмын агуулгатай мэдэгдэл хийж /тэрээр, Орос-Хятадын харилцаа түүхэндээ хамгийн сайн байна хэмээн мэдэгдэв/, БНХАУ хөрш орнуудтайгаа түншлэлийн харилцаа хөгжүүлэх чиг шугам баримталж буйгаа нотлон, энэ хоёр улс тус тусын энэхүү бодлогынхоо хүрээнд Монгол Улстай найрсгаар харилцаж, харилцан ашигтай хамтран ажиллах чиг шугамыг урт хугацаанд, тууштай баримтлахаа илэрхийлж байгаа нь нэн чухал юм. ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцаа найрсаг сайн байгаа нь эдгээр улстай харилцах таатай нөхцлийн нэг болж байгааг мөн дурдах нь зүйтэй.

2004 онд хэрэгжүүлэхээр зарчмын хувьд нэгэнт тохироод байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн ОХУ, БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын бэлтгэлийг улс төрийн болон прагматик агуулгаар нь сайтар хангаж, тодорхой үр дүнд хүргэх явдал манай гадаад харилцааны энэ жилийн нэг гол зорилт мөн. Эдгээр айлчлалаар хөрш орнуудтай харилцсан тодорхой үе шатыг нэгтгэн дүгнэж, цаашдын зорилтуудаа тодорхойлох болно.

Эцэст нь тэмдэглэхэд, хөрш хоёр оронтой харилцах харилцааг тэргүүлэх чиглэл хэмээн чухалчлахдаа бусад улс гүрэнтэй харилцах асуудлыг хойш тавих бодлого огт үгүй болохыг Та бүгд сайн мэдэж байгаа. Чухамдаа хөрш хоёр оронтой харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь бүс нутагтаа байр сууриа бэхжүүлэх бодлогын нэг хэсэг юм. Бүс нутгийн үйл амьдралд Монгол Улсын оролцоог хэрэгжүүлэхэд хоёр талын харилцааны зэрэгцээ олон талт хамтын ажиллагаа чухал шаардлагатай. Монгол Улс эргэн тойрондоо өрнөх хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцаас хоцрохыг хүсэхгүй бөгөөд энэ утгаар, одоо бодитойгоор хэрэгжиж буй Шанхайн хамтын ажиллагааны үйл явцыг анхааралтай ажиглан судалж байгаа билээ. Энэхүү сонирхол, судалгааны хүрээнд манай Гадаад хэргийн сайд ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын хуралдаанд зочноор оролцоод ирлээ. Тус байгууллагын гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нартай, мөн Бээжинд тогтмол үйл ажиллагаагаа эхэлж буй НБДГ-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргатай нь тус тус уулзаж, санал солилцсон дүнг нэгтгэн Монгол Улсаас тус байгууллагатай цаашид харилцах бодлогын тухайд санал боловсруулах болно. Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх янз бүрийн сувагтай болох нь зүйтэй бөгөөд энэхүү чиг шугамд дээрх үйл ажиллагаа нийцэж байгаа гэж үзнэ. Энэ тухайд эрдэмтэн, судлаач, Монгол төрийн гадаад бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулагч Та бүхэн тунгаан бодож, санал, бодлоо хэлж өгвөл талархах байна.